

ХАРХОРУМ ХОТЫН АРХЕОБОТАНИКИЙН СУДАЛГАА

Б.ОЮУНТУЯА¹, МАНФРЭД РЁШ²

¹МУИС, НШУС. Археологи-антропологийн тэнхим

Mail:oyuntuuya.batbold@yahoo.de

²Штуттгарт хотын Засгийн газрын дэргэдэх Хөшөө дурсгалыг хамгаалах газрын харьяа Археоботаникийн лаборатори, ХБНГУ

Mail:manfred.roesch@rps.bwl.de

Түлхүүр үг: Монголын үе, Хархорум хотын археологи, дундад зууны үеийн монголчуудын газар тариалан, археоботаник, жимс самрын үлдэгдэл

Өгүүллийн товч агуулга. Монгол улсын эртний нийслэл Хархорум хотын археоботаникийн судалгаагаар МЭ XIII-XV зууны үеийн хотын оршин суугчдын газар ашиглалт, өдөр тутмын хүнсний хэрэглээний талаар тодруулахыг зорилоо. Хархорум хотын оршин суугчид хотын ойролцоо усжуулалттай талбайд газар тариалан эрхлэхээс гадна гадаадын улс орнуудаас олон төрлийн нэмэлт амуу тариа, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо авчирч хэрэглэдэг, зарим төрлийн жимс самар, хүнсний ногоог байгалиас түүж ашигладаг байжээ. Тухайлбал, Гүзээлзгэнэ (*Fragaria*), Хушны самар (*Pinus sibirica*)-ыг байгалиас түүж, Хушга (*Juglans regia*), Нанжин Чавга (*Ziziphus jujube*), Инжир (*Ficus carica*), Усан Үзэм (*Vitis vinifera*) зэргийг гадны улс орнуудаас оруулж ирэн хэрэглэдэг байсан.

Хархорум хотын тууриас олдсон, 1346 оны гэрэлт хөшөөний монгол, хятад бичгийн дурсгалд “гинг луу жил-тул Корум-а сагаку балагасун оро сигулугсан ажгу” гэж бичсэн байдгийг судлаач Д.Гонгор (1978) “**хин луу** жил нь Чингис хааны ор суусан 15-р он буюу 1220 он болно” гэж Халх Товчооны 2-р дэвтэрт тайлбарласан байдаг. Энэхүү мэдээгээр Монголын Эзэнт гүрний нийслэлийг XIII зууны эхэн үед Чингис хааны зарлигаар Орхон голын хөндийд үүсгэн байгуулсан бололтой. Улмаар Өгөдэй хааны үед Хархорум хот нь өргөжин тэлж, Гүүг, Мөнх хаадын үед цэцэглэн хөгжсөөр 1260 онд Хубилай хааны зарлигаар Монголын нийслэлийг Шандуд шилжүүлэхэд Давааны Арын муж болон үлдсэн байна. Гэвч XV зууныг хүртэл хотын ач холбогдлоо хадгалсаар байсан бөгөөд Их Юань улсын үед буюу “1288 оноос эхлэн тариа тариулах албан цэргийг суулгадаг газар” (Пэрлээ, 1961: 85) болгожээ.

Энэхүү хот нь одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрт, Хангайн нурууны төгсгөл, Орхон голын хөндийд, Улаанбаатараас 365 км зайд, умард өргөргийн 47°12'63", дорнод уртрагийн 102°47'3" –д, далайн төвшнөөс дээш 1495 метр өндөрт оршдог. Тус нутаг дэвсгэр нь уулын ойт хээрийн бүслүүрт оршдог бөгөөд тал хээр газар шарилж, шаваг (*Artemisia*), төрөл бүрийн хялганат (*Stipa*) ургамал зонхилдог бол ойт хээр, ялангуяа уулын налуугаар хус (*Betula*), шинэс (*Larix sibirica*), нарсан (*Pinus*) ой элбэг тохиолддог (Өлзийхутаг, 1985).

Хархорум хотын туурийг анх 1948-1949 онд Зөвлөлт-Монголын хамтарсан хээрийн шинжилгээний анги малтан судалсан бөгөөд түүх, археологийн чиглэлээр

судалгаа явуулсан. Түүний дараа 1976-1986 оны хооронд Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэнгийн Археологийн секторын судлаачид хэсэгчлэн малтлага судалгаа хийсэн бол 1999 оноос Монгол-Германы хамтарсан археологийн судалгааны экспедици тус газарт түүх, археологи, археоботаникийн судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Дундад зууны Монголын Эзэнт гүрний нийслэл байсан энэхүү түүхэн газрыг судалгааны олон чиглэлээр судлах болсон явдал нь нүүдэлчдийн хот суурин, тэдгээрийн газар тариалангийн асуудлыг бага хэмжээгээр ч атугай хөндөн гаргах чухал алхам болсон юм.

Нэгэн хятад сурвалж бичигт “Монгол шивэй аймгийн газар нутаг чийглэг, тэд шар будаа, буудай тариалж байсан хэмээх ба Байегу (баяуд) баргужин төхөмийн орчимд тариалантай байжээ” (Гонгор, 1978: 361-362) гэж тэмдэглэснээс гадна XII-XIII зуунд холбогдох сурвалжийн мэдээнүүдэд “1180-аад онд Тэмүжин нар Мэргидийг довтлон эзлэхэд, тэднээс үр тариа олзолсон” (Гонгор, 1978: 362), “Буйр, Хүлэн нуур, Халхын голын орчимд Отчигин ноёны хувь нутагт тариа тариалж байсныг 1223 онд түүгээр дайран өнгөрсөн Чан чун нилээд тодорхой бичиж үлдээсэн” (Гонгор, 1978: 362) гэх мэтчилэн тэмдэглэн үлдээжээ. Мөн Монголын Нууц Товчооны (Гаадамба, 1990) 152-р зүйлд Хэрэйдийн ван хан Тоорилыг “... Сэлэнгийн Буур хээрт очоод Мэргидийн газар будаа нүдэж амьдарч явсан билээ”, 279-р зүйлд Өгөдэй хааны өгүүлснээр “... ноёд ах дүү нар чуулбал өглөг соёрхлыг өгч байя. Үүний тулд эд агуурс, мөнгө, сүх, нум, саадаг хуяг, зэв зэргийг байшин зооринд хадгалж, тэр байшин балгасыг сахиуля. Үүнийг зүг бүрээс балгасчин, **амуучин** нарыг томилж сахиуля” гэж тус тус тэмдэглэсэн байдаг.

Дундад зууны үед дорно зүгрүү аялан явсан европын аялагчдын тэмдэглэлд “Тэдэнд нэгэн бурхан буй бөгөөд түүнийгээ **Начигай** хэмээн нэрлэнэ. **Начигай** бол газар дэлхийн эзэн сахиусан бөгөөд тэдний үр хүүхэд, мал сүрэг болоод тариа будааг ч цөм ивээлдээ багтаадаг гэлцэнэ” (Марко Поло, 1987: 70), “хот эргэн тойрон шавар хэрэмтэй бөгөөд дөрвөн хаалгатай. Зүүн хаалганы дэргэд шар будаа зэрэг амуу тариа худалдаалах авч, тэдгээрийг авчрах нь баахан ховор” (Гильом Де Рубрук, 1988: 194), “тэд өвлийн цагт цагаан будаа, шар будаа, арвай, зөгийн бал тэргүүтнээр дарс мэт сайхан амтат ундаа хийнэ” (Гильом Де Рубрук, 1988: 109), “тэд арвайг (шар будаа) (Плано Карпини, 2006:27) няцалж нухаад устай буцалган идэхээр бус шууд залгилахаар болгоод өглөөд нэг хоёр аяга уугаад...” (Плано Карпини, 1988:24) гэх зэрэг мэдээнүүдийг үлдээсэн нь их сонирхолтой юм.

Үүний зэрэгцээ Хархорум хотын археологийн малтлагаас гарч буй олдворууд тухайлбал, зоосон мөнгө, шаазан, шилээр хийсэн сав суулга, ваар, газар тариалангийн багаж хэрэгсэл зэрэг олдворууд нь дундад зууны монголчууд хоол хүнсэндээ *арвай* (*Hordeum*), *буудай* (*Triticum*) болон хүнсний зарим ногоо, үр жимсийг өргөн хэрэглэдэг байсны нэгэн дам баримт гэж үзэж болох юм.

Мөн хээрийн шинжилгээний ангийн судалгааны хүрээнд агаараас авсан зурагны тусламжтайгаар хотын ойролцоох хөрсөнд газар тариалан эрхэлж байсан ул мөр илэрснээр археоботаникийн судалгаа хийж, нүүдэлчид, тэр дундаа дундад зууны үеийн монголчуудын газар тариалангийн тухай асуудлыг бичгийн сурвалж болон археологи, археоботаникийн судалгаагаар тодруулах шаардлагатай болсон юм. Хархорум хотын иргэд газар тариалан эрхэлж байсан эсэх талаар явуулж байсан судалгааны явцад арвай, буудай мэтийн үр тарианы ургамлаас гадна тариалж, хэрэглэж байсан, аль эсвэл гадны улс орноос худалдаа, арилжааны замаар орж ирсэн байж болохоор амтат үр жимс, хүнсний ногоо зэргийн сонирхолтой материалууд

олдсон юм. Тиймээс эдгээр материалуудад боловсруулалт хийж, үр жимсний төрлийн үлдэцийг ялган авч, Хархорум хотын иргэдийн өдөр тутмын амьдрал, газар боловруулалт, худалдаа арилжаанд дээрх ургамлын үлдэгдлүүдийн үүрэг ач холбогдлыг тодруулахаар энэхүү судалгааг хийлээ.

СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ БА АРГА ЗҮЙ

2002-2004 оны зун Хархорум хотын туурийн “Хааны ордны дүүрэг” (Баркманн 2007: 97) -ийн хэсгийн малтлагаас 10-20 л хэмжээтэй 2 хөрсний дээж, “Хотын төв гудамж”-ны малтлагын 5 м-ээс илүү зузаантай соёлт давхаргаас 100 орчим хөрсний дээж авсан. Шатсан болон шатаагүй соёлт давхаргуудаас модны нүүрс, шатсан болон шатаагүй ургамлын үр, жимс, амьтны яс, хайрга чулуу олдож байв. Хөрсний дээжүүдээс ургамлын үрийг ялган авахын тулд шороог 40 см диаметртэй, 0,5 мм-ийн өргөн нүхтэй, 4 шигших төхөөрөмжөөр, моторт шахуурга ашиглан усаар чийгшүүлэн шигшиж, шигшүүрт үлдсэн чийгтэй хэсгийг даавуунд боож салхинд хатаасны дараа 10 дахин өсгөгч микроскоп ашиглан төрөлжүүлэн ялгасан. Ургамлын үрийг таних судалгааг ХБНГУ-ын Штуттгарт хотын Засгийн газрын дэргэдэх Хөшөө дурсгалыг хамгаалах газрын харьяа Археоботаникийн лабораторит европ тивийн ургамлын цуглуулгатай харьцуулан тодорхойлсон бөгөөд зарим ургамлыг тодорхойлоход орос, монголын судлаачдын (Grubov, 1982; Өлзийхутаг, 1985) бүтээлүүдийг ашиглалаа.

Германы археоботаникчдын гаргасан Датенбанк программаар ургамлын үрийн бүртгэл хийж, тус программын дагалдах Эксел программаар статистикийн боловсруулалт хийсэн болно.

ҮР ДҮН БА ХЭЛЦЭМЖ

“Хааны ордны дүүрэг”-ийн малтлагаас авсан хөрсний дээжнээс амуу тарианы шатсан үлдэгдлүүдийн хамт Самрын мод (*Corylus avellana*), Чавганы төрөл (*Prunus*), Хушга (*Juglans regia*), Нанжин Чавга (*Ziziphus jujube*), Хушны самар (*Pinus sibirica*)-ын шатаагүй үлдэгдлүүд олдсон.

“Хотын төв гудамж”-ны хэсгийн малтлагаас 100 орчим дээжийг ялган авч үзэхэд, их хэмжээний модны нүүрстэй шатсан давхаргад амуу тариа, үр жимс олдож байсан боловч маш сул концентрацитай байсан. Харин хайргатай соёлт давхаргаас олдсон шатсан болон шатаагүй ургамлын үр, самар болон жимсний яснууд, шатсан амуу тариа, амьтны яс, модны нүүрс будааны хальс гэх мэт үлдэгдлүүд нь нилээд сайн нягтралтай байв. Дээрх дээжнүүдээс урьдчилсан байдлаар 242 ширхэг самар болон жимсний яснуудыг ялган авсан.

Жимс болон самрын үлдэцүүдийг харахад гадаадаас импортоор оруулж ирсэн байж болох үрнүүд зонхилох хувийг эзэлж байна. Учир нь монголын эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө хэт хүйтэрдэг нөхцөлд самар, жимсний мод, бут ургаж боломжгүй юм. Харин зарим нэг төрлийн үр жимсний үлдэц, тухайлбал, гүзээлзгэнэ (*Fragaria vesca*), хушны самар (*Pinus sibirica*), Чавганы төрөл (*Prunus*) зэргийг ой, хээр газраас түүвэрлэн хэрэглэх боломжтой байжээ. Гэхдээ нөгөө талаар дээрх 2-3 зүйлийн үр жимсийг мөн гаднаас импортлон оруулж ирж байсныг үгүйсгэх аргагүй юм.

Харьцангуй их хэмжээгээр олддог, усан үзэм (*Vitis vinifera*), инжир (*Ficus carica*), хятад нанжин чавга (*Ziziphus jujube*) зэрэг жимснүүдийг импортоор оруулж ирж байсан бөгөөд тэдгээрийг хойд Хятад, баруун хойд Энэтхэг, Кашмир, Туркестан зэрэг газруудаас авч ирсэн байж болох юм. Учир нь дээрх нэр дурьдсан газруудад

усан үзэм, инжир, хятад нанжин чавга зэрэг жимснүүд ургадаг гол бүс нутгууд ажээ (Roesch, Fischer, Maerke, 2005,14:485-492).

Чавга (*Prunus*)–ны төрлийн үр жимс нь ховор биш бөгөөд ихэвчлэн хятад болон Төв Азид элбэг тохиолддог байна (Roesch, Fischer, Maerke, 2005).

Цөөвтөр тоотой олдсон алим/лийр (*Malus/Pyrus*) нь хятадаас, хушга (*Juglans regia*) самар Гималайн бүсээс тус тус импортоор орж ирсэн бололтой (Roesch, Fischer, Maerke, 2005).

Судалгааны явцад киви (*Actinidia*), усан самар (*Trapa*) гэх 2 төрлийн сонирхолтой материал олдсон бөгөөд эдгээр нь судлагдан буй үед ховор зэрэглэлд орохоор жимсний төрлүүд юм. Кивиний үр “Хааны ордны дүүрэг”-ийн малтлагаас авсан дээжнээс 2 ширхэг, “Хотын төв гудамж”-ны хэсгээс авсан дээжнээс нэг үрийн 1/3-тэй тэнцэх хэмжээний жижиг хэсэг тус тус олдсон. Эдгээр материалыг орчин үеийн кивиний төрлүүд болох *Actinidia arguta*, *Actinidia kolomikta* зэрэг сорттой харьцуулж үзээд Киви (*Actinidia*)-гийн төрлийн үр болохыг тодорхойлсон боловч зүйлийг нь тогтоож чадаагүй байна.

Усан самар гэх жимсний талаар тодорхой мэдээлэл байхгүй байгаа бөгөөд дараа дараагийн судалгаанд харьцуулан судлах материал олдвол, нарийвчлан тогтооно гэтэгт итгэж байна.

Сурвалжийн мэдээ сэлтээс үзэхэд “Өгөдэй хаан ... Хархөрөмийн захаар дайран явжээ. Гэтэл нэг лангуун дээр тэмээн хөх болсон том жимс харагдсан байна. ...”, Тэрхүү тэмээний хөх шиг том жимсийг (тарвасын төрлийн ургамал бололтой, Б.О.) сайн ургаж болсных нь төлөө илүү мөнгө төлөх ёстой гэж Өгөдэй хаан үзсэн бөгөөд үүнийг Рашид Ад Диний “Судрын Чуулган” (2002: 60)-д тэмдэглэн үлдээсэн байна. Мөн дээрх сурвалжид “Хаан ан хийж явахад нь нэг хүн хулуу авчирч өгчээ ...” гэж бичсэнээс үзвэл хулуу болон тарвас гэх мэтчилэн том хэмжээтэй жимс, ногоог Хархорум хотын зах зээл болон энгийн ард иргэд худалдаалж эсвэл багахан хэмжээтэйгээр тарьж ургуулж байсан байж болох юм. Эдгээр ургамлууд нь хүнсний болоод жимсний төрлүүдийн ойлголтонд аль алинд нь багтдаг болохоор сурвалжийн мэдээн дэх хүнсний ногоо, үр жимс гэхчилэн бичсэний алин болохыг тогтоох аргагүй байна. Тухайлбал, “Чжан Дэ-хуэй Хархорумын хүн ам шар будаа, буудай, хүнсний ногоо тарьж байсныг үзжээ” (Гонгор, 1978: 362) гэсэн тэмдэглэл дээр **хүнсний ногоо** гэж бичсэн байдаг бөгөөд энэ нь амуу тариа тариалах ажлаас тусгайд нь хүнсний ногооны тариалах талбай байсныг ялгаж харсан байж болох мэдээ юм. Мөн “Тэгэхэд гэлэн үр жимс авч мориндоо мордож, түүнийг дагаж явав. ... Арабукхад жимс баривал тэрээр хүлээн авчээ” (Гильом Де Рубрук 1988: 195) гэж тэмдэглэсэн нь үр жимс гэснээс бус ямар төрлийн жимснүүд агуулж авч явсан тухай дурьдаагүй байна.

Ираны түүхч А.Жувейны зохиолд Өгөдэй хааныг Хархорумд бүйлсний мод тариалж, үр жимсийг нь хэрэглэж байсан тухай тэмдэглэн үлдээсэн байдаг. Хархорум хот нь Хангайн нурууны төгсгөлд, уулын ойт хээрийн бүслүүрт хамаарагддаг бөгөөд энд Бариулт бүйлс (*Prunus*-ын төрөл), улаан модот Яшил (Яшилын буюу *Ziziphus jujube*-гийн овог) зэрэг тохиолддог (Өлзийхутаг, 1985) нь дээрх А. Жувейны мэдээтэй давхцаж байна.

Дээрх мэдээнүүдээс үзвэл Хархорумын оршин суугчид нь газар тариалан эрхлэхээс гадна хүнсний ногоо тариалж байсан талаар цухас мэдээ гарч байгаа бөгөөд харин үр жимс тариалж байсан эсэх талаар тодорхой мэдээ баримт бидний уншсан сурвалжуудад тохиолдохгүй байгаа юм. Ховор төрлийн үр жимс, ялангуяа,

монголын эрс тэс уур амьсгалтай нөхцөлд ургах болон тариалах боломжгүй жимс, самрыг худалдаа арилжааны замаар хятад болон Дундад Азиас импортлон хааны ордны тансаг хэрэглээ болон хотын зарим баян чинээлэг иргэд, худалдаачдын хэрэгцээг хангадаг байсан нь ойлгомжтой. Мөн хаад ихсээс эхлэн энгийн ард иргэд байгалийн бэлэн бүтээгдэхүүн болох гүзээлзгэнэ (*Fragaria vesca*), хушны самар (*Pinus sibirica*), чавга (*Prunus*)-ны төрлийн зарим жимс, самрыг түүвэрлэх аргаар хүнсэндээ хэрэглэж байсан бололтой.

ДҮГНЭЛТ

Дундад зууны үед Монголын Эзэнт гүрний нийслэл Хархорум хотын иргэд нь олон үндэстнээс бүрэлдэн оршиж байсан бөгөөд нилээд төрлийн үр тарианы болон хүнсний ногооны ургамлуудыг тариалахын зэрэгцээ байгалийн бэлэн самар, жимсийг түүж хэрэглэх, зарим төрлийн жимс, самрыг худалдаа арилжааны замаар гаднаас оруулж ирэх зэргээр хоол хүнсэндээ хэрэглэж байжээ.

XIII зууны эхэн үе ба дунд үеүдэд холбогдох хөрсний дээжнээс жимс, самрын үлдэгдэл бараг олдоогүй нь хот суурингийн хөгжил XIII зууны эхэн үеэс II хагас хүртэл бүрэн тогтворжоогүй байсны илрэл буюу их бүтээн босголт өрнөж байсантай холбоотой юм. Нөгөө талаар газар тариалан, хүнсний ногоо тариалах ажлыг суралцах, хэвшүүлэх үйл явц давхар өрнөж байсантай ч холбоотой байж болох юм.

Бидний шинжилсэн хөрсний дээжүүдээс нийтдээ 10 төрлийн жимс, самрын яс болон үр гарсан бөгөөд эдгээрээс Гүзээлзгэнэ (*Fragaria vesca*), Хушны самар (*Pinus sibirica*) зэргийг байгалиас түүж хэрэглэж байсан бололтой. Харин Усан үзэм (*Vitis vinifera*), Хушга (*Juglans regia*), Нанжин чавга (*Ziziphus jujuba*), Инжир (*Ficus carica*) болон Алим/Лийрийн (*Malus/Pyrus*) төрлийн үр жимсийг худалдаа арилжааны замаар оруулж ирэн, хааны ордон болон хотод амьдарч байсан баян чинээлэг хүмүүсийн тансаг хэрэглээг хангаж байжээ гэж дүгнэж болох юм.


Нэн ховор төрлийн Киви (*Actinidia*), Трапа (*Trapa*) зэрэг нь мөн л худалдааны замаар, эсвэл өглөг барьц, бэлэг сэлтээр гадаадын улс орнуудаас ирдэг байсан байж болох ч одоогоор археоботаник болон сурвалж бичгийн мэдээнд харьцуулахаар зүйлс олдоогүй байна.

Дурьдан буй үеийн европын хот суурин мөнхүү олон төрлийн жимс, самрыг ургуулахын зэрэгцээ гадны улс орнуудаас импортлон авч ирдэг бөгөөд 100 ба түүнээс доош км зайнаас авдаг байв. Хархорум хотын хувьд Хятад, Дундад Азиас импортолдог байсан бөгөөд ойролцоогоор 1500-2000 км замыг туулдаг байсан бололтой.


Эцэст нь дурьдахад Хархорумын иргэд эдгээр 10 төрлийн жимс жимсгэнээс гадна олон, өөр төрлийн жимс, самрыг хэрэглэж байсан гэдэг нь гарцаагүй бөгөөд судалгааны явцад энэ талаар шинэ, шинэ үлдэцүүд илрэх нь дамжиггүй.

ТАЛАРХАЛ


Уг судалгааг хийж гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн Монгол-Германы хамтарсан “Хархорум” экспедицийн бүрэлдэхүүнд хамт ажилласан Герман, Монголын эрдэмтэд, судлаачид болон МУИС-ийн НШУС-ийн Археологи-антропологиин тэнхимийн эрдэмтэн багш нартаа талархал илэрхийлье.




Зураг 1. Хархорум хотын төв гудамжны малталтаас илэрсэн үр жимсний зураг



Зураг 2. Хотын төв гудамжны малтлагын 14-85-р квадратаас олдсон жимс, самрын үлдэц



Зураг 3. “Хотын төв гудамж”-ны малтлагын 14-85-р кватратаас гарсан жимс, самрын үлдэгдлийг квадрат тус бүрээр ангилсан нь



Зураг 4. Хотын төв гудамжны малтлагаас гарсан самар, жимсний үлдэгдлийг он цагаар ангилсан нь

НОМ ЗҮЙ

- Баркманн У. Б.*, 2007. Чингис хаан хийгээд түүний өв. УБ.
Гаадамба Ш., 1990. Монголын Нууц Товчоо. УБ.
Гильом Де Рубрук, 1988. Дорнод этгээдэд зорчсон минь. УБ.
Гонгор Д., 1978. Халх Товчоон. 2-р дэвтэр. УБ.
Марко Поло, 1987. Орчлонгийн элдэв сонин. УБ
Өлзийхутаг Н., 1985. БНМАУ-ын бэлчээр хадлан дахь тэжээлийн ургамал таних бичиг. УБ.
Плано Карпини, 1988. Монголчуудын түүх. УБ
Плано Карпини, 2006. Монголчуудын түүх. УБ
Пэрлээ Х., 1961. Монгол Ард улсын Эрт, дундад үеийн хот суурины товчоон. УБ.
Рашид Ад дин, 2002. Судрын Чуулган. 2-р дэвтэр. УБ.
Cappers R.T.J., Bekker R.M., Jans J.E.A., 2006. Digital seed Atlas of the Netherlands. Groningen.
Grubov V.I., 1982. Key to the Vascular Plants of Mongolia (with an atlas). Vol. 1,2. Leningrad.
Manfred Roesch, Elske Fischer, Tanja Maerke, 2005. Human diet and land use in the time of the Khans - Archaeobotanical research in the capital of the Mongolian Empire, Qara Qorum, Mongolia. *Veget Hist Archaeobot*, 14: 485-492. Stuttgart.
Oberdorfer E. 1994. *Pflanzensoziologische Exkursionsflora*. Stuttgart.
Walter Erhardt, Erich Goetz, Nils Boedeker, Siegmund Seybold. Zander Hand Woerterbuch der Pflanzennamen, Dictionary of plant names, Dictionnaire des noms des plantes. Auflage 17.

SUMMARY

B. Oyuntuya, Manfred Roesch

THE ARCHAEOBOTANICAL RESEARCH OF QARA QORUM

The inhabitants of the medieval Mongolian capital Qara Qorum used many cultivated and some wild gathered plants as food. The same holds true for about 10 species of fruits and nuts, most of which were also found in European towns, but rather rarely and more frequently only in later periods; they are regarded as indicators for a refined lifestyle. Apart from some wild gathered species like *Pinus sibirica* and *Fragaria vesca*, most of the fruits and nuts as for instance *Vitis vinifera*, *Ficus carica*, *Ziziphus jujuba*, *Prunus* and *Actinidia* or *Juglans regia* must also have been imported from quite long distances. Whereas in Europe imported plants came from a distance of normally not more than several hundred km or less, the production sites of the imported plants consumed in Qara Qorum were in China or central Asia to mention the most imported areas; that is distances of 1500-2000 km and more, separated from the consumer site by huge deserts.